



ГААЛИЙН ХИЛ, ТҮҮНИЙ ОНЦЛОГ.

*МУИС-ийн Хууль зүйн сургуулийн
захиргааны эрх зүйн тэнхимийн
багш, докторант Ж.Жавзандулам.*

Аливаа улсын оршин тогтнох үндэсийг тодорхой нутаг дэвсгэргүйгээр төсөөлөх аргагүй бөгөөд улс орон бүр өөрийн нутаг дэвсгэрийн дотор онцгой бүрэн эрх эдэлдэг. Улс үндэстнүүдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн ойлголт нь "Хил" "хязгаар" гэсэн нэр томъёотой салшгүй холбоотой юм. "Хил" гэсэн энэхүү ойлголт нь аливаа улсын оршин тогтнох материаллаг үндэс болсон газар нутгаар хязгаарлагдаж тэнд эрх зүйн баталгаатай орчин бий болж хэрэгжин биелэх үндэс болно. Монгол Улсын хил, гаалийн хил гэсэн ойлголтоос онол, практикийн ач холбогдлыг тодорхойлох нь танин мэдэхүйн шинж чанартай асуудал төдийгүй хууль зүйн тодорхой үр дагавар бүхий ойлголт мөн. Монгол Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах зорилго нь хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээг хэрэгжүүлэх, хил болон хил орчмын дэглэмийн сахиулах улсын хилээр зорчигч тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхэд хяналт тавих зэрэг олон талтай үйл ажиллагааны илрэл байдаг.

Гаалийн болон хилийн зөрчлийн харъяаллыг тогтоох, гарсан зөрчлийг суурхай шийдвэрлэхэд хил гаалийн байгууллагуудын хамтын ажиллагаа чухал боловч тус тусын үүрэг зорилго өөр өөр эрх зүйн тодорхой актаар хуульчлан зохицуулагдаж байдаг. Улсын хилийн тусгаарлан тогтоосон тусгай шугамыг онол, практикийн хувьд байгалийн хил, зохиомол хил гэж хоёр ангилж үздэг.

Байгалийн хил гэдэг нь Монгол орны уул нуруу, гол мөрөн, газар нутгаар тогтоосон хууль зүйн ач холбогдол бүхий шулуун шугамыг хэлэх бөгөөд, харин зохиомол хил гэдэг нь хоёр улсын хилийн харъяалал, заагийг тогтоохын тулд босгосон тэмдэг багана хана, суваг замыг байгуулж бий болгох ойлголт байдаг.

Эдгээр асуудал нь олон улсын гэрээ конвенцэд хуульчлан тусгагдсан хил орчмын болон хилийн шугам тогтооход онцгой ач

холбогдол бүхий нэр томъёо мөн. Улсын хил, гаалийн хилийн өвөрмөц онцлогыг гаргаж тавихын тулд тэдгээрийн зорилго, үйл ажиллагааны зарчмыг тодорхойлох нь чухал юм.

Монгол Улсын гаалийн тухай хуулийн гуравдугаар зүйлийн хоёр дахь хэсэгт " Монгол Улсын хил, Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байгуулагдсан гаалийн тусгай бүс, гаалийн баталгаат бүсийг гаалийн нутаг дэвсгэрээс тусгаарласан шугамыг гаалийн хил гэж томъёолон хуульчилсан байна. Үүнээс үзэхэд " хил" гэсэн нэр томъёо ямар нэгэн нутаг дэвсгэрийг бусдаас тусгаарлан зааглахын тулд, бий болгож буй зориудын шулуун шугам юм.

Улсын хилийг тогтоох гол зарчим нь тодорхой тэмдэг, тогтвортой юмсыг, хооронд нь шулуун шугамаар холбосон тасралтгүй үргэлжилсэн тэмдгээр илэрхийлдэг. Улсын хил, гаалийн хил нь тодорхойлолт, нэр томъёоны хувьд нийтлэг шинж агуулж байгаа ч үйл ажиллагааны зорилго чиглэлийн хувьд өвөрмөц онцлогтой.

Монгол Улсын хилийн халдашгүй дархан байдал нь маш тогтвортой шинжийг агуулахаас гадна нутаг дэвсгэрийн дээд эрх эдэлж байдаг. Түүнчлэн тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, аюулгүй байдлын эрх зүйн бүрэн баталгаагаар хангагдсан байдаг оршино. Тэгэхдээ улсын хил огт өөрчлөгдөхгүй зүйл биш улсын хилийн шугамыг хамтран шалгах явцад өөрчлөгдөх шаардлага гарвал энэ тухай олон улсын гэрээний заалтыг үндэслэн тухайн улсын төрийн эрх барих байгууллагаар хуульчлан баталгаажуулсны эцэст сая хүчин төгөлдөр болох жишээтэй.

Олон улсын түвшинд улс үндэстнүүдийн хооронд улсын хил өөрчлөх практик ховор тохиолддог бөгөөд ихэвчлэн хилийн маргаантай орчинд хэрэгждэг асуудал юм. Тэгвэл Монгол Улсын гаалийн хилийг Монгол Улсын гаалийн байгууллагаас гаалийн хяналт шалгалт хийх, гаалийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор тогтоодог бөгөөд "Гаалийн хилийг" гадаад дотоод гэж хоёр ангилдаг. Гаалийн гадаад дотоод хил нь гаалийн байгууллагын оршин буй байрлалтай шууд холбоотой ойлголт юм.

Монгол Улсын гаалийн хилд гаалийн байгууллага эрх хэмжээнийхээ дотор хяналт тогтоож, гаалийн байгууллагаас гарсан горим журмыг мөрдлөг болгон ажиллана. Монгол Улсын хил, гаалийн хил нь тодорхой орчинд давхцах тухай ойлголт байдаг боловч үнэн хэрэг дээрээ улсын хил дээр шууд нэг шугаман дээр хяналт шалгалт явагддаг үйл ажиллагаа огтхон ч биш гааль, хилийн байгууллагуудын хяналтын чиглэл зорилго, өөр өөр байх бөгөөд гаалийн байгууллага хилийн байгууллагууд хил хамгаалах байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд хяналт шалгалтаар хамтран хийж болохыг

үгүйсгэхгүй.

Орчин үед улсын хил хяналтын байгууллага, гаалийн байгууллагын хамтын ажиллгааны хүрээнд үндэсний аюулгүй байдлыг хангах, гадаад оронтой харилцан ашигтай хамтран ажиллах гэх мэт нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллаж байна.

"Гаалийн хил" тогтоосноор тэнд гаалийн хууль тогтоомж үйлчлэх хүрээ бий болж, ингэснээрээ бараа тээврийн хэрэгсэл, зорчигчдын хувийн хэрэглээний эд зүйлс, гаалийн хяналт шалгалт хийж, гаалийн татвар тариф ноогдуулан гаалийн бүрдүүлэлт хийх, гаалийн татвараас хөнгөлөх, чөлөөлөх гэх мэт олон талтай үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Гаалийн хилд хийх хяналт шалгалтыг бодвол улсын хилийн хяналт шалгалт өргөн хүрээтэй онцгой чухал хяналт байдаг. Гаалийн хилийг зөвхөн гаалийн хяналт шалгалт хийх зорилгоор байгуулж байдгаараа өвөрмөц онцлогтой.

Өнөөдөр хилийн боомтод ажиллах албадын хамтын ажиллагааг боловсронгуй болгох, тэнд ажиллагсдын нийгмийн баталгааг сайжруулах тэдгээртэй холбоотой хууль эрх зүйн орчинг бүрдүүлж тусгаар улсыхаа хил хамгаалалтад иргэн бүрийг оролцуулах нь Монгол Улсын төрийн бодлогын нэг чухал зорилго мөн.

*

*

*

Хил, гааль судлагчдад тусламж

1925 оны Гаалийн архив сөхвөөс...

Хил, гааль хоёр ажиллах объект, үйл ажиллагааны зорилго, харилцах субъект зэрэг олон талаараа ялангуяа хилийн асуудлар олон жилийн туршид хамтран ажиллаж иржээ. 1925 оны үест зөвхөн Хөвсгөлийн хойд хил дээр гааль, гаалийн түшмэд ямар чухал үүрэг гүйцэтгэж байсныг товч авч үзье.

Энэ үед Ханхын гааль, Хантайшир уулын аймгийн Жаргалан уулын сумын гааль, Хөвсгөл далай Бүрэнхан уулын хошууны гааль, Хатгал дах гааль, түрээсний хороо, Хантайшир уулын аймгийн Жаргалан-Уул сумын Сартолгойн гааль, Хантайшир уулын Баянзүрх уулын хошууны гааль, Их шавь Дархад нутгийн гааль, Богд хан уулын Хангай хайрхан уулын хошууны Ар гөрөөчин сумын гааль гэх зэрэг олон газар гааль түрээсийн хороо ажиллаж байжээ.

А/. Гааль зарим онцлог хэрэгт үнэмлэх шийтгэн олгодог байв. 15/ 1925/ оны Цагаан сарын 22-ны өдөр 200 дугаар үнэмлэх бичиг шийтгэн